



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2020 оны 06 сарын 26 өдөр

Дугаар Е/07

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

Улсын Их Хурлын ээлжит
сонгуулийн дүнгийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал хураалт 06 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдаж, Сонгуулийн ерөнхий хороо 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнг хэлэлцэн, сонгуулийн 29 тойрог тус бүрт хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай тогтоол гаргаснаа олон нийтэд мэдээлжээ.

Гэсэн ч сонгуулийн урьдчилсан дүнг мэдээлснээс хойш сонгуульд оролцсон зарим нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн зүгээс санал авах, дүнг нэгтгэх үйл ажиллагааны явцад хууль зөрчсөн үйлдэл олноор гарсан, зарим нэр дэвшигчийн саналыг тоолох явцад таслал бүхий тэмдэглэгээ гарч ирсэн, сонгуулийн автоматжуулсан системд нөлөөлж, саналын дүнг будлиантуулсан байж болзошгүй гэх зэрэг асуудлыг олон нийтийн сүлжээнд тавьж байгаа төдийгүй миний нэр дээр өргөдөл, гомдол ирүүлсээр байна.

Сонгуулийн үр дүнд үүссэн энэ асуудал нь зөвхөн нам, эвслээс нэр дэвшигч, бие даагч нарын гомдлоор хязгаарлагдахгүйгээр иргэдийн дунд ч эргэлзээ, хардлага дагуулсан нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих нийгмийн асуудал боллоо.

Сонгуулийн тухай хуульд Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих зарчмыг баримтлах үүрэгтэй байхаар хуульчилсан байдаг.

Миний бие Монгол Улсын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч болохын хувьд Монгол Улсын иргэн бүр Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх барих эрхээ дөрвөн жилд нэг удаа эдэлж, сонгосон сонголтдоо сонгогч бүр бат итгэлтэй байх ёстой хэмээн үзэж байна.

2020000050

Иймд 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн нийт 29 тойрог тус бүрийн саналын хуудсыг нэр дэвшигчид, иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулан хуульд нийцүүлэн гараар тоолж, хяналтын тооллогыг яаралтай зохион байгуулах замаар сонгуулийн дүнг бататган, олон нийтэд мэдээлэн, үүсээд буй эргэлзээг нэг мөр арилгах талаар зохих арга хэмжээг авч ажиллана уу.

Хавсралт ¹⁸ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА